



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/25/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 57
танай _____ ны № _____ т

ЭРДМИЙН ӨРГӨӨ ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ЯНЖМАА
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020053

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,549,012.00	129,223,837.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	735,450.00	1,025,450.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	735,450.00	1,025,450.00
3121	Төгрөг	735,450.00	1,025,450.00
31211	Төрийн сангийн харилцах	735,450.00	1,025,450.00
33	АВЛАГА	00.00	19,099,200.00
335	Бусад авлага	00.00	19,099,200.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	19,099,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	98,813,562.00	109,099,187.00
351	Түүхий эд материал	25,881,684.26	25,448,659.26
35110	Тусгай зориулалттай материал	24,728,349.26	24,728,349.26
35130	Эм боох материал	1,153,335.00	720,310.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,283,866.34	11,283,866.34
354	Хангамжийн материал	56,173,011.40	66,771,661.40
35410	Бичиг хэргийн материал	1,688,850.00	1,117,950.00
35420	Аж ахуйн материал	46,492,762.00	57,474,312.00
35440	Түлш, шатах тослох материал	330,000.00	76,000.00
35450	Барилгын засварын материал	5,282,784.00	5,724,784.00
35470	Бусад хангамжийн материал	2,378,615.40	2,378,615.40
35600	Мал амьтад	5,475,000.00	5,595,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,119,316,608.03	1,948,503,543.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,119,316,608.03	1,948,503,543.86
392	Биет хөрөнгө	1,803,269,358.01	1,632,618,793.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,766,631,757.00	1,766,631,757.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-284,619,518.62	-394,124,776.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	220,144,498.86	246,228,811.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-82,918,142.66	-148,268,677.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,824,743.73	104,298,743.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,902,402.31	-70,327,865.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	176,920,818.00	176,920,818.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-61,394,082.11	-74,451,223.57
39217	Ном	22,581,686.12	25,711,206.12
393	Биет бус хөрөнгө	316,047,250.02	315,884,749.88
39301	Програм хангамж	917,500.00	917,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-686,249.98	-848,750.12
39303	Бусад биет бус хөрөнгө	315,816,000.00	315,816,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,218,865,620.03	2,077,727,380.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,218,865,620.03	2,077,727,380.86
51	Засгийн газрын хувь оролцоо	2,218,865,620.03	2,077,727,380.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,850,088,184.62	1,850,088,184.62
51101	Өмч: - төрийн	1,850,088,184.62	1,850,088,184.62
512	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	4,192,991,441.92	4,334,129,681.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-141,138,239.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,561,768,877.33	4,561,768,877.33

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,218,865,620.03	2,077,727,380.86
---	---	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,801,596,803.66	2,246,073,432.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	569,137,503.66	8,301,463.10
120	Нийтлэг татварын бус орлого	569,137,503.66	8,301,463.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	569,137,503.66	8,301,463.10
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,435,450.00	1,857,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	566,702,053.66	6,444,463.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	277,951,800.00	345,706,369.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,954,507,500.00	1,892,065,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,613,200.00	47,530,796.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	720,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	21,810,796.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,893,200.00	25,720,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,338,600.00	298,175,573.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,338,600.00	298,175,573.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,335,746,886.55	2,387,561,671.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,335,746,886.55	2,387,561,671.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,207,429,379.46	2,296,776,009.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,586,455,685.14	1,560,517,570.55
210101	Үндсэн цалин	938,318,406.88	820,451,234.00
210102	Нэмэгдэл	462,765,042.59	604,845,876.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,814,292.63	49,961,113.00
210104	Урамшуулал	143,557,943.04	85,259,347.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,457,013.77	203,077,051.70
210201	Тэтгэврийн даатгал	126,567,107.82	143,449,945.66
210202	Тэтгэмжийн даатгал	15,507,068.00	14,710,843.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,071,523.61	12,204,105.57
210204	Ажилгүйдлийн даатгал	4,055,417.00	2,954,363.19
210205	Эрүүл мэндийн даатгал	39,255,897.34	29,757,793.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,874,788.00	294,975,573.00
210301	Гэрэл, цахилгаан	7,095,996.00	7,050,273.00
210302	Түлш, халаалт	249,747,774.00	272,375,300.00
210303	Цэвэр, бохир ус	13,031,018.00	15,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,762,076.00	7,989,220.00
210401	Бичиг хэрэг	3,471,280.00	2,545,130.00
210402	Тээвэр, шатахуун	1,767,620.00	1,347,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,199,941.00	1,334,040.00
210404	Ном, хэвлэл	278,740.00	396,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	634,000.00	2,366,400.00

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,410,495.00	00.00
2105	Нормативт зардал	294,682.00	3,190,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	294,682.00	1,401,480.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,789,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,521,644.00	2,423,800.00
210604	Урсгал засвар	8,521,644.00	2,423,800.00
2107	Томилолт, зочны зардал	424,000.00	144,000.00
210702	Дотоод албан томилолт	424,000.00	144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	949,000.00	3,610,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	625,000.00	3,610,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,690,490.55	220,848,114.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,300.00	16,207,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	829,540.00	1,140,167.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	127,806,650.55	203,500,897.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,317,507.09	90,785,661.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,258,600.00	68,308,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,978,600.00	63,822,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,280,000.00	4,486,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	90,181,725.09	22,476,761.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,181,725.09	22,476,761.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	877,182.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	877,182.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	465,849,917.11	-141,488,239.17
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,705,000.00	2,940,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,705,000.00	2,940,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,765,000.00	2,590,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,430,000.00	2,250,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,335,000.00	340,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,060,000.00	350,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	464,789,917.11	-141,138,239.17

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	-4,657,781,359.03	1,754,075,702.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	-4,657,781,359.03	1,754,075,702.92
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	464,789,917.11	464,789,917.11
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	-4,192,991,441.92	2,218,865,620.03
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	-4,192,991,441.92	2,218,865,620.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	-4,192,991,441.92	2,218,865,620.03
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-141,138,239.17	-141,138,239.17
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	-4,334,129,681.09	2,077,727,380.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,234,894,750.00	2,239,628,969.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,435,450.00	1,857,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,435,450.00	1,857,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,435,450.00	1,857,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,435,450.00	1,857,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,232,459,300.00	2,237,771,969.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,954,507,500.00	1,892,065,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,613,200.00	47,530,796.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	720,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	21,810,796.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,893,200.00	25,720,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,338,600.00	298,175,573.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,338,600.00	298,175,573.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,222,403,900.00	2,211,721,449.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,222,403,900.00	2,211,721,449.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,094,686,392.91	2,121,725,787.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,586,455,685.14	1,560,517,570.55
210101	Үндсэн цалин	849,051,680.88	820,451,234.00
210102	Нэмэгдэл	537,356,101.59	604,845,876.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,892,148.63	49,961,113.00
210104	Урамшуулал	157,155,754.04	85,259,347.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,457,013.77	203,077,051.70
210201	Тэтгэврийн даатгал	135,535,085.82	143,449,945.66
210202	Тэтгэмжийн даатгал	15,746,226.00	14,710,843.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,576,798.00	12,204,105.57
210204	Ажилгүйдлийн даатгал	3,115,192.00	2,954,363.19
210205	Эрүүл мэндийн даатгал	31,483,711.95	29,757,793.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,874,788.00	294,975,573.00
210301	Гэрэл, цахилгаан	7,095,996.00	7,050,273.00
210302	Түлш, халаалт	249,747,774.00	272,375,300.00
210303	Цэвэр, бохир ус	13,031,018.00	15,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,778,236.00	9,002,170.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	1,729,180.00
210402	Тээвэр, шатахуун	1,047,620.00	943,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,199,941.00	1,334,040.00
210404	Ном, хэвлэл	835,290.00	396,160.00

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,106,925.00	2,720,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,788,460.00	1,878,500.00
2105	Нормативт зардал	2,280,450.00	3,094,405.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	164,900.00	402,655.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,115,550.00	2,691,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,618,530.00	19,524,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	16,324,600.00
210604	Урсгал засвар	2,618,530.00	3,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	424,000.00	144,000.00
210702	Дотоод албан томилолт	424,000.00	144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,997,400.00	11,438,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,673,400.00	11,438,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,800,290.00	19,952,317.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	15,676,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,800,290.00	4,276,037.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,717,507.09	89,995,661.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,658,600.00	67,518,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,978,600.00	63,822,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,680,000.00	3,696,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	90,181,725.09	22476565,75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,181,725.09	22476565,75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	877,182.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт санхүүжилт/	877,182.00	196.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,490,850.00	27,907,520.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,755,400.00	27,617,520.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,755,400.00	27,617,520.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,755,400.00	27,617,520.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,755,400.00	27,617,520.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,755,400.00	-27,617,520.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	735,450.00	290,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	735,450.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	735,450.00	1,025,450.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,190,241,173.00	2,167,764,607.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,190,241,173.00	2,167,764,607.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,123,886,873.00	2,103,612,707.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,574,235,800.00	1,560,517,570.55
210101	Үндсэн цалин	832,302,500.00	820,451,234.00
210102	Нэмэгдэл	605,272,300.00	604,845,876.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,500,000.00	49,961,113.00
210104	Урамшуулал	90,161,000.00	85,259,347.00

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,321,900.00	203,077,051.70
210201	Тэтгэврийн даатгал	146,232,400.00	143,449,945.66
210202	Тэтгэмжийн даатгал	15,276,400.00	14,710,843.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,663,900.00	12,204,105.57
210204	Ажилгүйдлийн даатгал	3,104,500.00	2,954,363.19
210205	Эрүүл мэндийн даатгал	31,044,700.00	29,757,793.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	294,975,573.00	294,975,573.00
210301	Гэрэл, цахилгаан	7,050,273.00	7,050,273.00
210302	Түлш, халаалт	272,375,300.00	272,375,300.00
210303	Цэвэр, бохир ус	15,550,000.00	15,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,349,200.00	8,829,570.00
210401	Бичиг хэрэг	938,600.00	938,580.00
210402	Тээвэр, шатахуун	944,100.00	943,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,417,500.00	1,334,040.00
210404	Ном, хэвлэл	751,200.00	511,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,617,600.00	2,430,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,680,200.00	2,671,500.00
2105	Нормативт зардал	3,123,700.00	3,094,405.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	403,600.00	402,655.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,720,100.00	2,691,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,239,600.00	20,239,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,324,600.00	16,324,600.00
210602	Тавилга	715,000.00	715,000.00
210604	Урсгал засвар	3,200,000.00	3,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	538,600.00	144,000.00
210702	Дотоод албан томилолт	538,600.00	144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,910,000.00	4,818,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,910,000.00	4,818,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8192500.00	7916837.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,990,800.00	1,963,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,201,700.00	5,953,537.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66354300.00	64151900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,354,300.00	64,151,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65,738,300.00	63,822,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	616,000.00	329,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,190,241,173.00	2,190,241,173.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,892,065,600.00	1,892,065,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,892,065,600.00	1,892,065,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	298,175,573.00	298,175,573.00
132001	Орон нутгийн төсвөөс	298,175,573.00	298,175,573.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	735,450.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,025,450.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	101.00	101.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	87.00	87.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		47,530,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		47,530,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		47,530,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,080,600.00

210401	Бичиг хэрэг		790,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	34050000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		34,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1800000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,800,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	47530796.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		47,530,796.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		21,810,796.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		25,720,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд нийт 31 багш, ажилтан 205 суралцагч үйл ажиллагаагаа явуулжээ.

Энэ хичээлийн жилд “Суралцагчдад аюулгүй ээлтэй орчин бүрдүүлж, суралцах суурь чадварыг баттай эзэмшүүлэн, эцэг эхний оролцоог нэмэгдүүлэх” гэсэн зорилгыг тавин ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 2339.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 23.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.4 сая төгрөгөөр өссөн нь авлага, үндсэн хөрөнгө, бараа материал өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0.00	19099.2	19,099.20

Бараа материал	98813.562	109099.187	10,285.63
Үндсэн хөрөнгө	2,603,837.00	2,636,524.80	32,687.80
Нийт хөрөнгө	2,703,386.01	2,765,748.64	62,362.62
Өглөг			0.00
Хуримтлагдсан үр дүн	-4,192,991.44	-4,192,991.44	0.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,218,865.62	2,077,727.38	62,362.62

Авлага: Тайлант онд шинээр 19.1 сая төгрөгийн авлага үүссэн нь оны эцэст төсөвт зохицуулалт хийснээр цахим самбар, математик танхим тохижуулах хөрөнгө худалдан авах гэрээг хийж 2022 оны 01 дүгээр сарын 31-нд бараа нийлүүлэхээр гэрээнд тусгаж санхүүжилтийг олгосноор авлага үүссэн байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 98.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 109.1 сая төгрөг болж өмнөх оноос 10.3 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 40.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 36.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 0.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 30.6 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 28.0 сая төгрөг зарцуулж, үнэ төлбөргүй болон акталж устгасан 0.3 сая төгрөгийн туслах аж ахуйн мал байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2603.8 сая, эцсийн үлдэгдэл 2636.5 сая төгрөг болж өмнөх оноос 32.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 27.6, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5.1 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр: Өр төлбөр данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 2190.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1892.1 сая төгрөгийг улсын төсвөөс 298.2 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1892.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 298.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, 2167.8 мянган төгрөгийг зарцуулж 22.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2167.8 сая төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 13.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 5.2, хангамж 0.5, урсгал шилжүүлэг 2.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагч БСШУЯ-наас цахим хичээлийн контент боловсруулах зардалд 19.0, ТХБ-2 төслөөс номын сангийн засварт 15.0, боловсролын чанар шинэчлэлийн төсөлд 10.6, аймгийн БСГ-аас ариутгал халдвар хамгаалал 0.3, сурагчдаас хоцрогдлын үнэлгээний шалгалтанд бичиг хэргийн зардалд зориулж 0.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, аймгийн ЗДТГ-аас шагналд 1.8 нийт 47.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, бичиг хэргийн зардалд 0.7, ариутгалд 0.3, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 10.6, бараа үйлчилгээний бусад 34.0, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1.8 сая төгрөгийн зарцуулах эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 1.03 хувиар буюу 22.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт хэмнэлт гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 119 мэдээллээс 119 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2774600, багаж хэрэгслийн зардлаас 3324600 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 13000000 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг холбогдох заалттай нийцэхгүй байна.

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 173 нэр төрлийн 96964648.86 төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит

хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 5422.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрч алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж давтан гарсан тул албан шаардлага өглөө.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар байгууллагад биет хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 121.2 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 5.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 19.1 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгч, 96.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтээс хэмнэсэн 169727 төгрөгийн санхүүжилтийг бууруулсан байхад төвлөрүүлэг шилжүүлгээр бүртгэсэн, шилжүүлэн авсан 5070313.1 төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авснаар бүртгэснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна. гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт: байхгүй

4.3 Албан шаардлага

Тайлант онд хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2774600, багаж хэрэгслийн зардлаас 3324600 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 13000000 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Бараа материалын тооллогыг хийсэн боловч баримт материалын бүрдэл дутуу байна.

1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогын анхан шатны баримтын бүрдлийг хангаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

3.1 Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 173 төрлийн 96.9 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хасаагүй тайланд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	4	121.2	1	5.2			1	19.1	96.9	2
Дүн										